



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



СПОРТЫН АРБИТРЫН ДҮРЭМ

2023 оны 11 дугаар сарын 01-ны
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 23/16 тоот
тогтоолын хавсралтаар батлав.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ДҮРЭМ

НЭГ. СПОРТЫН АРБИТР, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 1.1. Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитр (цаашид “Спортын арбитр” гэх) нь спорттой холбоотой хэрэг маргааныг арбитрын журмаар бие даан, хараат бусаар явуулах Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны дэргэдэх төрөлжсөн, байнгын үйл ажиллагаатай арбитр мөн.
- 1.2. Спортын арбитр нь гадаад, дотоодын орон тооны бус 21-ээс дээш арбитрчийн гишүүнтэй байж, тэдгээрийн бүртгэл хөтөлж, нэг эсвэл гурван арбитрчаас бүрдсэн арбитрын бүрэлдэхүүнээр шийдвэрлэх үүрэгтэй байгууллага байна.
- 1.3. Холбоо нь эвлэрүүлэн зуучлагчдын бүртгэл хөтөлж, спорттой холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар шийдвэрлэх боломжоор хангадаг. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Эвлэрүүлэн зуучлах дүрмээр зохицуулна.
- 1.1. Спортын арбитрын дэргэд допингийн Давж заалдах комисс ажиллана. Давж заалдах комисс нь допингийн эсрэг дүрмийг зөрчсөнтэй холбоотой хэрэг, маргааныг бие даан, хараат бусаар анхан болон давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа (үр дүнгийн удирдлагын ажиллагаа)-г явуулж, шийдвэр гаргах зорилго бүхий байнгын үйл ажиллагаатай Комисс мөн. Комиссын дүрэм, хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг Холбооны Удирдах зөвлөлөөс баталж, мөрдүүлнэ.
- 1.4. Спортын арбитр нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.
- 1.5. Спортын арбитрын гишүүдийг Монголын Үндэсний Олимпын Хороо, дотоод болон гадаадын спортын холбоо, клуб, спортыг идэвхитэй дэмждэг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон Холбооноос нэр дэвшүүлж 2 (хоёр) жилийн хугацаатайгаар сонгоно.
- 1.6. Спортын арбитр нь өөрийн салбарыг гадаад болон дотоодод, аймгуудад байгуулж болох бөгөөд тэдгээрийг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.
- 1.7. Спортын арбитр нь өөрийн эмблем, нэр бүхий тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.8. Спортын арбитр талуудын хүсэлтээр түр арбитрт арбитрын ажиллагаа явуулахад туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.
- 1.9. Салбар арбитр нь эд хөрөнгө санхүүгийн тайлан тооцоо, арбитрын хураамжийн зарцуулалт, арбитрчдын урамшууллын талаарх тайлан мэдээллийг улирал бүр МОУҮС Арбитрт ирүүлнэ.
- 1.10. Спортын арбитрын үндсэн чиг үүрэг:
 - 1.10.1. Спортын арбитр, Комисс болон Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг дэмжих, олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх;
 - 1.10.2. Спортын арбитрын хэлэлцээр, харьяалал бүхий маргааныг шийдвэрлэх;
 - 1.10.3. Комисс нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрмүүдэд заасан допингтой холбоотой харьяалуулсан маргааныг шийдвэрлэх;
 - 1.10.4. Олон улсын болон тивийн, бүсийн, улсын болон төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.
 - 1.10.5. Спортын холбоо, клуб, нийгэмлэг болон хөрөнгө оруулагч, хуулийн этгээд, олон нийтэд таниулан сурталчлах, энэ зорилгоор танилцуулга, гарын авлага, ном гаргах, соён гэгээрүүлэх ажил явуулах.
 - 1.10.6. Спортын арбитрын ажиллагааны талаар судалгааны ажил хийх, сургалт зохион байгуулах, арбитрчдыг мэргэшүүлэх;

- 1.10.7. Олон улсын арбитрын байгууллагуудтай хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэх
- 1.10.8. Спортын арбитрын ажиллагааны нууцыг хадгалж, ажиллагааг хараат бус, шударгаар түргэн шуурхай явуулах зэрэг болно.

ХОЁР. СПОРТЫН АРБИТРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Холбооны Удирдах зөвлөл Спортын арбитрын дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - 2.1.1. Спортын арбитрыг байгуулах, дүрмийг батлах;
 - 2.1.2. Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг батлах;
 - 2.1.3. Спортын арбитрын зардлын журмыг батлах;
 - 2.1.4. Комисс байгуулах, дүрмийг батлах;
 - 2.1.5. Зардал хуваарилах журмыг батлах;
 - 2.1.6. Спортын арбитрын арбитрчдын нэрсийн жагсаалтыг батлах, өөрчлөлт оруулах;
 - 2.1.7. Спортын арбитрын жил бүрийн төсөв, гүйцэтгэлийг батлах;
 - 2.1.8. Холбогдох дүрэм, журмыг батлах;
 - 2.1.9. Хууль болон дүрэм, журамд заасан бүрэн эрх;
- 2.2. Спортын арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон санхүүгийн хувьд бие даасан, хараат бус ажиллах, нөхцөлийг хангах талаар Холбоо болон салбар бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 2.3. Спортын арбитр нь дараах бүтэц зохион байгуулалттай байна:
 - 2.3.1. Ерөнхийлөгч
 - 2.3.2. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга
 - 2.3.3. Арбитрчид
 - 2.3.4. Комисс
 - 2.3.5. Нарийн бичгийн дарга
- 2.4. Спортын арбитрын Ерөнхийлөгч нь хууль зүйн салбарт 10 (арав)-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай, түүний 5 (тав)-аас доошгүй жил удирдах ажил эрхэлж байсан, нэр хүндтэй, эрх зүйч мэргэжилтэй хуульч хүн байна.
- 2.5. Спортын арбитрын Ерөнхийлөгч нь хууль, хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон энэхүү дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тушаал, шийдвэр хэлбэртэй байна.
- 2.6. Спортын арбитрын Ерөнхийлөгч нь Комиссын дарга байна.
- 2.7. Спортын арбитрын Ерөнхийлөгч дараах эрх үүрэгтэй.
 - 2.7.1. спортын арбитрыг гадаад, дотоодод аливаа асуудлаар итгэмжлэлгүй төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 2.7.2. спортын арбитрыг төлөөлөн бусдаас бэлэг, хандив, тусламж хүлээн авах;
 - 2.7.3. спортын арбитрын үйл ажиллагаа хөгжүүлэх зорилгоор бодлого боловсруулах, үйл ажиллагааг сурталчлах, төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 2.7.4. спортын арбитрчийг хугацаанаас нь өмнө чөлөөлж, түүнийг түр орлох хүнийг томилох;
 - 2.7.5. Арбитрын тухай хууль, Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүрэмд заасан бүрэн эрх хэмжээний хүрээнд арбитрын ажиллагаанд оролцож шийдвэр гаргах;
 - 2.7.6. Спортын арбитрын нэрсийн жагсаалтад оруулах арбитрчдыг сонгох, нэр дэвшүүлэх;
 - 2.7.7. Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга, мэргэжилтэн томилох, чөлөөлөх;
 - 2.7.8. салбар арбитрын дарга, арбитрчдыг томилох, чөлөөлөх;
 - 2.7.9. Холбооны Удирдах зөвлөлд хамааруулснаас бусад дүрэм, журмыг батлах;
 - 2.7.10. хууль болон дүрэм, журамд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 2.8. Спортын арбитрын захиргааны үйл ажиллагааг эрхлэгч нь Ажлын алба байна. Ажлын албыг Ажлын албаны дарга удирдаж хэрэг хянан шийдвэрлэх хэвийн үйл ажиллагааг хангаж, нарийн бичгийн

дарга нарыг удирдлагаар хангах болон ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 2.9. Спортын арбитрын Ажлын албаны дарга түүний эрх, үүрэг
 - 2.9.1. спортын арбитрын хэрэг үүсгэх, хэргийн дугаар олгох;
 - 2.9.2. спортын арбитрын хэргийн бүртгэлийг зохион байгуулах;
 - 2.9.3. нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүрдүүлбэрийг хянах, бүрдүүлбэр хангах хугацаа тогтоох, буцаах;
 - 2.9.4. хэргийг нарийн бичгийн даргад хуваарилах;
 - 2.9.5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг тогтмол хангаж, нарийн бичгийн дарга нарыг удирдах, үүрэг даалгаврыг өгөх;
 - 2.9.6. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой арбитрын бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх болон хүсэлтийг шийдвэрлэх;
 - 2.9.7. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесстой холбоотой Бүрэлдэхүүнд санал, зөвлөмж өгөх;
 - 2.9.8. Спортын арбитрын үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх, бэхжүүлэх, боловсронгуй болгох, сурталчлах ажлыг хийх;
 - 2.9.9. Спортын арбитрч болон нарийн бичгийн дарга нарыг сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах
 - 2.9.10. Ерөнхийлөгчийн эзгүйд түүний эрх үүргийг хэрэгжүүлэх;
 - 2.9.11. Ерөнхийлөгчийн эрх олгосноор гадаад дотоодод төлөөлөх, хамтын ажиллагааг өргөжүүлэх;
 - 2.9.12. Арбитрын хууль, биеийн тамир, спортын хууль, допингийн эсрэг үндэсний дүрмийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах;
 - 2.9.13. хууль болон дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

ГУРАВ. АРБИТРЧИД

- 3.1. Спортын арбитрын арбитрчид нь хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, мэргэшсэн хуульч, спортын мэргэжил, цол зэрэг дэвтэй тамирчин, спортын ажлын дадлага туршлагатай /багш, дасгалжуулагч, спортын шүүгч/, тухайн спортын төрлөөр нарийн мэргэшсэн, эрдэмтэн, багш байх ба эрүүгийн ял шийтгэл эдэлж байгаагүй 35-аас дээш настай байх шалгуурыг хангасан гадаад, дотоодын иргэд нэр дэвшиж Холбооны Удирдах зөвлөлөөс 2 жилийн хугацаагаар нэрсийн жагсаалтыг батална.
- 3.2. Холбооны Удирдах зөвлөл нь хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчдээс сонгож, сонгогдсон арбитрчдын нэрсийг эрэмбэлэхдээ Монгол цагаан толгойн дэс дарааллыг баримтална.
- 3.3. Спортын арбитрчид “Спортын арбитрч би Олон улсын болон Үндэсний биеийн тамир, спортын байгууллага, тамирчдын эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж спортын хэрэг, маргааныг хараат бусаар, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Олон Улсын спортын конвенц, Олимпын Харт-д спортын арбитрчийн ёс зүйг чанд сахиж явахаа батлан тангарагъя. Миний бие өргөсөн тангаргаасаа няцвал ёс зүйн хатуу цээрлэлийг хүлээнэ” гэсэн тангаргийг Спортын арбитрын туганд өргөж, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.4. Спортын арбитрын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гишүүнд “Хүндэт гишүүн”-ий өргөмжлөл, шагнал олгож болно. Хүндэт гишүүний өргөмжлөлийн загвар, журмыг Удирдах зөвлөл батална. Хүндэт гишүүний өргөмжлөлийг гишүүний дурсамж, дурсгалд зориулан нөхөн олгож болно.

- 3.5. Спортын арбитрчдын нэрсийн жагсаалтад орох хүсэлт гаргасан иргэдийн хүсэлт, мөн арбитрчдыг арбитрчдын нэрсийн жагсаалтаас хасах, улируулан сонгох асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.
- 3.6. Спортын арбитрын нэрсийн жагсаалтад орсон арбитрчийг Комиссын даргын шийдвэрээр Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Бүрэлдэхүүнд оролцуулж болно.
- 3.7. Комиссын явуулж буй аливаа ажиллагаанд оролцохгүй. Мөн Комиссын гишүүн нь Спортын арбитрын үйл ажиллагаанд оролцохгүй.
- 3.8. Спортын арбитрчид нь Монгол Улсын бусад байнгын арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалт буюу бүрэлдэхүүнд харьяалагдахгүй байх.
- 3.9. Спортын арбитрчид болон эвлэрүүлэн зуучлагчид Спортын арбитрын өмнө аливаа талын хуульчийн эсвэл шинжээчийн үүрэг гүйцэтгэхгүй.
- 3.10. Спортын арбитрч дараах эрхийг эдэлнэ.
 - 3.10.1. арбитрчаар сонгогдох, томилогдох, татгалзах;
 - 3.10.2. хэргийн материалтай танилцах, энэ талаар мэдээлэл авах;
 - 3.10.3. арбитрын ажиллагааг шуурхай явуулах талаар санал гаргах, нарийн бичгийн даргад үүрэг өгөх, ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт гаргах;
 - 3.10.4. арбитрчийн урамшуулал буюу хөлс авах;
- 3.11. Спортын арбитрч дараах үүргийг хүлээнэ.
 - 3.11.1. Арбитраас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцох;
 - 3.11.2. Арбитрын үйл ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар сургалтад жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа заавал хамрагдах;
 - 3.11.3. Арбитрын бүрэлдэхүүнд нь орсон хэргийн ажиллагаанд идэвхтэй, санаачлагатай, шуурхай ажиллах;
 - 3.11.4. Арбитрын ажиллагааны нууцыг задруулахгүй байх;
 - 3.11.5. хариуцлагатай, өндөр ёс зүйтэй байх;
 - 3.11.6. хараат бус, бие даасан, бусдын аливаа нөлөөллөөс ангид байх;
 - 3.11.7. хараат бус, бие даасан байдалд нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн аливаа үйлдлийг нэн даруй мэдээлэх;
 - 3.11.8. бусад үүрэг;
- 3.12. Спортын арбитрч, эвлэрүүлэн зуучлагчид томилогдмогцоо өөрсдийн чиг үүргийг энэхүү дүрмийн заалтуудад нийцүүлэн бүрэн дүүрэн, бодитой, хараат бусаар, биечлэн хэрэгжлүүлэх үүрэг хүлээсэн албан ёсны мэдэгдэлд гарын үсэг зурна.
- 3.13. Бүрэлдэхүүнд орсон Спортын арбитрч нь тухайн маргааны талаар талууд болон төлөөлөгч, өмгөөлөгч нарт өмнө нь мэргэжлийн зөвлөгөө үзүүлж байгаагүй, тэдгээрийн төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн хувьд холбоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
- 3.14. Спортын арбитрчдыг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлж, нэрсийн жагсаалтаас хасна. Үүнд;
 - 3.14.1. өөрөө хүсэлт гаргасан;
 - 3.14.2. нар барсан;
 - 3.14.3. эрх зүйн чадамжгүй болсон;
 - 3.14.4. Спортын арбитрын ёс зүйн дүрмийг зөрчсөн;
 - 3.14.5. авлига, хээл хахууль авсан нь нотлогдсон;
 - 3.14.6. Спортын арбитрын нэр хүндэд харшилсан үйлдэл эс үйдэл гаргасан;
 - 3.14.7. ажиллахад харшлах өөр ажил, албан тушаалд томилогдсон;
 - 3.14.8. энэхүү дүрмийн 3.11.2-3.11.7-д заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зөрчсөн;

ДӨРӨВ. АЖЛЫН АЛБА

- 4.1. Ажлын алба нь Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, хуралдааны нарийн бичгийн дарга, мэргэжилтнээс бүрдэнэ.
- 4.2. Хуралдааны нарийн бичгийн дарга нь эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 4.2.1. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргаас хуваарилсан Спортын арбитрын хэргийг хүлээн авч арбитрын ажиллагааг эхлүүлэх ажиллагааг шуурхай явуулах;
 - 4.2.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллах;
 - 4.2.3. хэргийг илтгэх, хуралдааны бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх, тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцах;
 - 4.2.4. Бүрэлдэхүүн болон талуудыг хэргийн талаарх мэдээллээр хангах;
 - 4.2.5. Спортын арбитрын ажиллагаа болон хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;
 - 4.2.6. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргад арбитрын ажиллагааны талаар шуурхай мэдээлж, дэмжлэг тусламж авах;
 - 4.2.7. Бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай гүйцэтгэх;
 - 4.2.8. Спортын арбитрын ажиллагааны нууцыг чандлан хадгалах;
 - 4.2.9. Бусад;
- 4.3. Мэргэжилтэн нь эрх зүйч, орчуулагч, гадаад харилцааны мэргэжилтэй байж болох бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 4.3.1. үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, маркетинг, хүний нөөц, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалт
 - 4.3.2. гадаад, дотоод хамтын ажиллагаа
 - 4.3.3. судалгаа, сургалт, шинжилгээ
 - 4.3.4. мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ
 - 4.3.5. бусад

ТАВ. АРБИТРЧДЫН ЗӨВЛӨЛ

- 5.1. Спортын арбитрын үйл ажиллагаа, чиг үүрэг, зорилго, зорилт, бодлогыг тодорхойлох, гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх, бэхжүүлэхэд арбитрчдын оролцоог хангах, арбитрчдыг мэргэшүүлэх, сургах, давтан сургах, арбитрчдын ёс зүйн асуудлыг хэлэлцэх, хууль болон арбитрын ажиллагаатай холбоотой холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий арбитрчдын төлөөллөөс бүрдсэн “Арбитрчдын зөвлөл”-ийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр байгуулж болно.
- 5.2. Арбитрчдын зөвлөл нь 7 гишүүнтэй байна. Үүнд: Ерөнхийлөгч, Ажлын албаны дарга орох бөгөөд үлдэх 5 гишүүнийг арбитрчдаас сонгоно.
- 5.3. Арбитрчдын зөвлөлийн ажиллах журам, зохион байгуулалтын журмыг Ерөнхийлөгч батална.

ЗУРГАА. АРБИТРААС ТӨРИЙН БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ

- 6.1. Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллагаас арбитрын үйл ажиллагаанд, Спортын арбитраас төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим баримтална.
- 6.2. Спортын арбитр хэрэг хянан шийдвэрлэхээс бусад асуудлаар өөрийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдах асуудлаар төр, засгийн байгууллагатай зөвшилцөх, хэлэлцээр хийх, хамтран ажиллах, шаардлага тавих зэргээр ажиллана.
- 6.3. Спортын арбитр нь бусад олон улсын болон төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоод, танхим, арбитртай харилцахдаа харилцан хүндэтгэх, дэмжин туслах, хамтран ажиллах зарчим баримтална.

ДОЛОО. САНХҮҮ, ТӨСӨВ

- 7.1 Спортын арбитрын төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 7.1.1 Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал;
 - 7.1.2 Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал;
 - 7.1.3 Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардал;
 - 7.1.4 Лавлагаа, мэдээлэл, архив, бусад үйлчилгээний хураамжийн орлого;
 - 7.1.5 Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын болон дотоодын аж ахуйн нэгж, холбоо, иргэний бэлэг, хандив, дэмжлэг, тусламжийн орлого;
 - 7.1.6 Спорт, спортын арбитр, допинг, эвлэрүүлэн зуучлал болон түүнд хамаарал бүхий салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчны судалгаа шинжилгээ явуулах орлого;
 - 7.1.7 Сургалтыг эрхлэх, дахин сургах, мэргэшүүлэх орлого;
 - 7.1.8 Уулзалт, семинар зохион байгуулах үйл ажиллагааны орлого;
 - 7.1.9 Хэвлэн нийтлэх үйл ажиллагааны орлого;
 - 7.1.10 Өвийн болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж олсон орлого, хөрөнгө;
 - 7.1.11 Үүсгэн байгуулагч, Удирдах зөвлөлийн гишүүдээс өгсөн хандив;
 - 7.1.12 Дүрэмд заасан үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 7.1.13 Бусад орлого

НАЙМ. БУСАД

- 8.1. Энэхүү дүрмийг Удирдах зөвлөлөөс баталж, хүчин төгөлдөр мөрдөнө.